



“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 6/159

Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтан томилох тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, Монгол Улсын их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус компанийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, холбогдох тайлан мэдээг гаргах, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах эрх бүхий албан тушаалтнаар Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Г.Мөнгөнтуяаг томилсугай.

2.Эрх бүхий албан тушаалтан Г.Мөнгөнтуяад үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх нэмэгдэл олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Ариунжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагаандаа Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг чанд баримталж ажиллахыг эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Түр орлон гүйцэтгэгч бүрэн эрхэт төлөөлөгчийн 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн Б/81 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.АРИУН-ЭРДЭНЭ